

МОНГОЛ – ТУВА БИЧГИЙН ХЭЛНИЙ ДУНДЫН ҮГИЙН САН

Д. Баасанбат*

Монгол- тува хэлний үгийн санг харьцуулан судлахын тулд хоёр ард түмний түүхийг сөхөн үзэх, эрт эдүгээгийн харилцааг судлах нь зайлшгүй билээ. Тувачууд нь өнө эртнээс Төв азийн томоохон өндөрлөгүүд болох Тагна, Соён, Сийлхэм, Алтайн нурууны баруун зүүн биеэр нутаглаж байжээ. Тагнын нуруу болон Алтайн салбар уулсад хийсэн антропологийн малтлагын дүнгээс үзэхэд хуучин чулуун зэвсгийн хожуу үеийн хүн амьдран суусны гэрч болох олдвор олджээ.

Чингис хаан Тува аймгийг эрхэндээ оруулж авсан тухай *“Туулай жил /1207 он/ Зүчи баруун гарын цэргийг авч Ойрад, Буриад, Барга, Урсуд, Хабаханас, Хомханас, Тува аймгийг оруулаад ...ирэв.” /МНТ. 1990, 208/* гэсэн нь ой тайгаар нутаглагч жижиг буурай аймгуудыг баруун гарын цэрэг онцын эсэргүүцэлгүйгээр эзэлж авсан түүхэн баримтыг дурджээ. Ийнхүү тувачуудын хоцрогдмол тархай бутархай, ан агнуурын олзыг харан нүүдэллэдэг байдалд нь түүхэн өөрчлөлт орж, монгол соёлын нөлөө дэлгэрч эхэлсэн нь Тувагийн ёс заншил, аман бэлгэ зүй зэргийг хөгжихөд чухал нөлөө үзүүлсэн юм.

“1757-1762 оны орчим Алтайн урианхайн долоон хошууг байгуулж Ховдын амбанд, Тагнын урианхайн дөрвөн хошууг байгуулж Улиастайн амбанд тус тус захируулсан бөгөөд хожим Алтайн урианхай тувачууд монголдоо үлдэж, Тагнын урианхай 1921-1944 оны хооронд бие даасан БНТУ болон оршин тогтнож байгаад ЗХУ-ын бүрэлдэхүүнд орсон билээ. Энэ бүх бодит баримтаас харах юм бол 1207 оноос хойш Тува, Монголчууд нэгэн төрийн дор нэгдэн түүхийн урт удаан хугацааг хамтдаа туулсан нь харагдаж байна” Б.Цэдэн-Иш гэжээ. Энэ хугацаанд монгол- тува хэлний хооронд адилсах, хувьсах, шинэ нэр томъёо үүсэх, нийгмийн байгуулал өөрчлөгдөх тусам хэл ярианд гарсан өөрчлөлтүүд монгол- тува нарт өөр өөрөөр нөлөөлж байсан байна.

Хэлний судлагдахуун дотроос олон хэлний хэлхээ холбоог хамгийн их тусгаж байдаг салбар бол тухайн хэлний үгийн сан мөн. Иймээс хүн төрөлхтөнд үйлчилж буй бүх амьд хэлийг хэлхээ холбоо бүхий шүтэн барилдсан хэл гэж болох бөгөөд тэдний нэг нь монгол хэл болно. Орчин цагийн монгол хэл, түүний үгийн сан цэвэр цул, дан ганц монгол хэлний уугал үгээс бүрдсэн биш, монгол хэлний үгийн санд орос, англи, франц, герман, түрэг, манж, төвд, хятад, самгард, араб зэрэг олон хэлний үг хэллэг буй бөгөөд, хэлхээ холбоо бүхий шүтэн барилдсан хэлийг бүрдүүлж байгаа болно.

XIII-XIV зууны үед Ази-Европын өргөн уудам газар нутагт, олон улс үндэстнийг нэгтгэсэн Монголын их гүрний ноёрхол тогтож, тухайн улс үндэстний хэлний харилцан нөлөөлөл ихээхэн идэвхжиж, түүний дунд монгол хэл ноёрхогч үндэстний хэлний

* МУИС-ийн МХСС-ийн багш, дэд профессор

хувиар тэдгээрийг холбогч гүүр болоод төвд, хятад, солонгос, манж, орос, дундад азийн болон араб дахины олон хэл аялгуунд харь үг хэллэг нэвтрэн ороход багагүй үүрэг гүйцэтгэсэн байна. “Улс гүрний хоорондын соёл, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн зүйл бүрийн харилцаа холбоо өргөжсн тэлэхийн хэрээр төрөл, төрөл бус хэлний дундын үг бий болох үзэгдэл нийтлэг байна. Европ дахины хэлнүүдийн хувьд ийм дундын үг их төлөв грек, латин хэлний гаралтай үг байдаг бол, ойрх болон дундад дорнодод араб, перс хэлний гаралтай, алс дорнодод хятад хэлний гаралтай үг зонхилох байдалтай байдаг” (Ж. Баянсан нар: 1995, 176)

Нэг хэлнээс нөгөө хэлэнд үг орохдоо нэг бол шууд, үгүй бол дам дамжин ордог байна. Жишээ нь: Хятад гаралтай үг монгол хэлэнд их төлөв аман яриагаар дамжин шууд орж ирсэн бол, европ хэлний үг, мөн грек, араб, самгарди гаралтай үг ихэнхдээ ном зохиолын орчуулгаар дамжин орсон байна. Үүнчлэн иран, түрэг, төвд, манж, орос гаралтай үг монгол хэлэнд их төлөв шууд орсон байна.

Тухайн хэлэнд амаар дамжин орсон үг авианы хувиралд нэлээд орсон байхад, бичгийн хэлээр дамжиж орсон үг харьцангуй тогтвортой байдаг байна. Иймээс монгол-тува хэлний дундын үгийг харьцуулан судлах нь, хоёр хэлний гарал үүсэл, харилцаа холбоог улам тодруулах онол, арга зүйн ач холбогдолтой байгааг тодорхойлж байгаа юм.

Түрэг болон тува, монгол хэлнүүд авиа, бүтцийн хувьд төсөөтэй. Ерөнхийдөө монгол хэл, тува хэлэнд нөлөөлөхдөө үгийн сангийн хувьд монгол хэлнээс зээлдсэн үгсийн тоо бусад хэлнээс хавьгүй их байна. Мөн энэхүү зээллэг үгс нь цаг хугацааны хувьд харьцангуй сүүлд гэж болно.

ХҮ-ХҮН зууны үед шарын шашин дэлгэрсэнтэй холбогдон Төвд-Монгол хэлний харилцан нөлөөлөл гүнзгийрсэн нь баруун монголын ойрд аялгуугуур дамжин тува хэлэнд ч бас нөлөөлснийг тод үсгийн дурсгалууд баталдаг. Ойрд аялгууны нэлээд олон үг хэллэг, тува хэлний үгийн санд орсон бөгөөд тодорхой тусгагдсан байдаг. Тухайлбал:

тув: “домбу” цайны төмөр сав,
дөр: “домбо” цай уудалдаг модон буюу төмөр сав.
тув: “тербе өг” буюу “эсгий гэр”
ойр: “терме хараач” “төмөр сараалжин гэр”
дөр: “хараач” гэрийн тооно
дөр: “хасавчи” гэрийн бүслүүр тогтоох мод
монг: “хатавч” гэх мэт үг хэллэг тохиолдоно.

Өнөөгийн ойрд аялгуунд ихээхэн нөлөө үзүүлсэн жишээг ч бид тува хэлний баримт, аман зохиол, баруун монголын баатарлаг туульсуудын үг хэллэгээс ч мэдэж болохын зэрэгцээ тувагийн аман зохиолд монгол хэлний маш их нөлөө байдгийг мэдэж болно.

Монгол хэл Тува хэлэнд нөлөөлснийг:

1-рт: Тува хэлэнд шууд орсон үг хэллэг байна. Ийм үгс нь аман ярианаас гадна ном зохиолд хадгалагдаж үлджээ. Жишээ нь:

мон:	тув:
агаар	агаар
арга	арга
бэл “уулын”	бэл
дуран	дуран

тайга	тайга
хүрээ	хүрээ
алба	алба
алдар	алдар
ан	ан
багана	багана
бардам	бардам
билиг	билиг
бөгтөр	бөгтүр ...г.м.

2-рт: Тувачууд 18-р зууны сүүлч 19-р зууны эхэн үеийн халх аялгуунд үндэслэж авиа сэлгэж дуудсан утга нь ижил дундын үг нэлээд байна.

тува	мон бич	монг
барыын	барагун	баруун
бужар	бужар	бузар
сава	саба	сав
серээ	сэрэгэ	сэрээ
тары-	тари	тарь
төгерик	төгүриг	төгрөг
бажа	база	баз
баринтак	баринтаг	баринтаг
денгер	тнгри	тэнгэр
бошка	бошогу	бошго
хораа	хорий-а	хороо

Иймэрхүү тогтоц тува хэлэнд дэх монгол зээллэгийн шинж болж өгдөг.

3-рт: Монгол хэлээр дамжин харь хэлнээс орсон үг байна. Тухайлбал төвд хэлнээс монгол хэлээр дамжин орсон буюу монгол хэлний үгийн сангаас зээлдсэн үг нэлээд байна. 15-17-р зууны үед Монголд бурханы шашин дэлгэрсэнтэй холбогдон төвд монгол хэлний харилцан нөлөөлөл гүнзгийрч Тувад бурханы шашин нэвтэрсэн тул, түүнтэй холбоотой нэр томъёог монгол хэл болон баруун монголын ойрд аялгуугаар дамжуулан зээлж авчээ. Эдгээрийг шашин соёлоор дамжин орсон үг ч гэж болно.

мон:	тув:
аюуш хадаг	айыжы хадак
баринтаг	баринтак
богд гэгээн	богда кегээн
богд	богда
бурхан сахиус	бурган сагыызын
дуган	дуган
зул	чула
лам	лама

4-рт: Буддын шашин нь монголчуудаар дамжин Тувад орсныг анхаарч үзвэл төвд хэлний гаралтай тува ормол үгс нь монгол эх сурвалждаа хэлбэрээрээ, төвд үгнээс илүү монгол үгэнд ойрхон байдгийг тайлбарлахад хялбар болно. жишээ нь:

монг:	төв:	тув:
барчид,	-бар-чид,	барчыт-нүгэл,
диваажин,	бдэбачан,	дываажан
гүрэм,	скурим,	хүрүм "залбирал",

сан,	бсанс,	сан "сан тавих",
лам,	блама,	лама "лам",
хамба,	мкхан-по,	хамба сүмийн дээд мяндагтан,
гэлэн,	дгэслонг	хелин "гэлэн",
цам,	чхам,	сам "шашины бүжиг",
хадаг,	кха-бтагс,	хадак "бэлгийн алчуур",

Үүн дээр төвдийн анагаах ухааны цөөн хэллэгүүд нэмэгдэнэ.

МОНГ:	төв:	тув:
ханд,	кханда,	ханды "ханд"
бумба "ариун рашааны сав,	бум-па,	бумба "бумба"
үрэл,	рил-бу,	үрүлэ "эм",
тун,	-тхун,	тун "доз-эм",

Мөн төвд гаралтай соёл- ахуйн хүрээнд хэрэглэгддэг үгс нь монгол хэлний эх сурвалжаас гаралтай гэдэг нь маргаангүй байна. Үүнд:

МОНГ:	төв:	тув:
маяг,	ма-ийг, "эх захиа"	майык "хэлбэр, загвар"
шил	шел "болор"	шил- "шил",
шал,	шал, "индэр, шал",	шала "шал",
горим,	го-римс,	корум- "дараалал, сахилга бат",
намтар,	"намтхар, амьдралын бичилт",	намдар- "намтар",
сая,	са-йа,	сая- "сая",
тэг,	тхик, тэг, бөөрөнхий",	тик- "тэг",
цэг,	тхик, тэг, бөөрөнхий",	сек- "анхаарлын тэмдэг",
хэвлэлийн бар,	драп	пар- "хэвлэмэл бар"
хавсай, гурилан боовны төрөл,	-	капсай- "гурилаар хийсэн боов"
домбо, данх, тув:	-	домбу- "зэс домбон данх" г.м.

5-рт: Нийгмийн өөрчлөлттэй холбогдон гарч ирсэн шинэ үг хэллэг монгол хэлэнд олон бий. Ардын хувьсгалын жилүүдэд монголын төр, соёлын амьдралд гарсан өөрчлөлтөөс шалтгаалан шинэ үг хэллэг гарсан нь тухайн үедээ тува хэлэнд шууд утгаараа бас шууд дуудлагаараа дамжин орсон байна. Жишээ нь:

мон:	тув:
гишүүн	кеъшигүн
дарга	дарга
хоршоо	корышаа
хөдөө	көдээ

6-рт: Монгол хэлний зарим холбон бэлгэдсэн үг Тува хэлний ихэнх холбоо, хоршоо үгстэй гадаад байдал болон утгаараа адил төстэй байгаа нь тохиолдлын чанартай адилтгал гэж үзэж болохгүй ба энэ нь үндсэндээ монгол хэлнээс зээлдэн авсан үгсийн үр дүн юм. жишээ нь:

мон:	тув:
сахилга журам	сагылга чурум
үр сад	үре сады
хурал цуглаан	хурал суглаа
эрдэм соёл	эртем союл

хүрээ хийд
идэр залуу
ач тус
дур зориг
учир утга

хүрээ хиит
идьер чалыы
ачы дуза
тура соруг

ужур утка... г.м. эдгээр холбон бэлгэдсэн үг нь тува хэлнээ эртний бичгийн хэлний дуудлагатай ойролцоо байгааг бас анзаарч болно. Энэ мэтээр монгол хэлнээс зээлдсэн үг хэллэг тува хэлэнд нэн элбэг өргөн тархсан их хэрэглэдэг байна. Эдгээр бүх үг хэллэгийг монгол тува хэлний дундын үгэнд хамааруулж болно.

7-рт: Монгол хэлний аман аялгуунуудаас зээлдэж авсан үг нь тува хэлний үгийн санд ингэж өргөн тархсан. тухайлбал, тувачуудтай холбоотой монгол ястан (*монгол, халх, дөрвөд, өөлд, дархад, буриад*), мөн монгол хэлний хэрэглүүрээр ойлголцдог зарим өөр угсаатнууд (*хятад, манж, төвд, тангуд*)-тай холбоотой юм.

Тува хэлэнд дэх гэртэй холбоотой нэрс, гэрийн тэжээмэл амьтадтай холбоотой нэр, зарим нэг нутгийн аялгууны үг хэллэг, 12 жилийн амьтдын нэр зэрэг нь монгол гаралтай юм. Бас феодал ноёдын цол хэргэм, засаг төрийн бүрэлдэхүүний нэрс, хуучин засаг захиргааны нэгжийн аль нь ч зээлдэн орсон болно.

8-рт: Монгол хэлний зээлдсэн үгс Тува хэлэнд язгуураараа байна.

монг: бүсэл- "*бүслэх, тойрон авах, хаах, хаалт хийх*" < *бүсэ -бүс*,"

тув: бүзээле- "*тойрон авах, хаах, хаалт хийх*",

монг: идээлэ- "*-идэх, хооллох*",

тув: идээле- "*цатгалд, бялуур*"

монг: төсөвлө- "*таамаглах, урьдчилан төлөвлөх*" < *төсүб, төсөв, таамаг*,"

тув: дөзевилле- "*төсөвлө*",

монг: "*жолооч, хоточ, улаач*" < *жолоо-цулбуур оосор, жолоо* " гэх мэт.

тув: чолаачы "*-жолооч*"

монг: бодтой, "*бод- эд юм, бодис*",

тув: боттуг "*онцгой, бодит, үнэн*",

монг:-тавтай, "*тайван, тав тухтай, яаралгүй, тайван, тав тух*",

тув: таптыг — "*тааламжтай, гоо үзэсгэлэнтэй, сайтар*",

монг: томоотой, "*журамтай, буурьтай, томоо, журам, буурь*",

тув: томаанныг "*номхон, аядуу*",

монг: төлөвтэй, "*биеэ барих чадвартай, дэг журамтай, тайван дуулгавартай*"

тув: төлөптиг "*сайн хүмүүжсэн, дэг журамтай*".

Одоогийн судалгаа тооцоогоор монгол хэлнээс зээлдсэн үгс нь тува \урианхай\ хэлний үгийн санд 30-аас доошгүй хувийг эзэлдэг гэж судлаачид үздэг.

9-рт: Өөр хэлтэй бусад оронтой нягт харилцаатай байх нь ихэнхдээ тухайн орны бэлэн үгсийг ашиглан өөрийн улс орондоо зээлдэн авч хэрэглэхэд хүргэдэг. Эдгээр үг зээлдэх нь шинэ үгийн хэрэгцээ нэлээд хэрэгтэй байвал бусад хэлнээс үг зээлдэн авах нь ярилцахад арай хялбар болдог. Монголын хэлний үгийн сангаас ойролцоо утгат бүлэг үг зээлсэн байдаг.

мон бич:

монг:

тув:

доригун,

дориун,

доруун "*нэлээд сайн, зохимжтой*",

жүгэр

зүгээр,

чүгээр "*сайн, сайн байна.*",

баругтай

барагтай.

барыктыг "*гайгүй, болмоор*",

гогомай,

гоомой

хоомай "*хүрэлцээгүй*",

тагарау	тааруу таарыы	“муу тааруу”,
адаг,	адаг	адак “төгсгөлийн, нам дор”, г. м.
түргэн,	түргэн,	дүрген “хурдан яаруу зэрэг”
габсигаи	гавшгай,	кашпагай “хурдан шаламгай”,
шалаб,	шалав	шалын “хурдан түргэн”,
магуда-,	мууд,	моода- “сульдах, хүч чадалгүй болох”,
моко-,	мох,	мога- “ядрах, тамирдах”,
гачигда-,	гачигд,	качыгда- “зовох тамирдах”,
болбасура-,	боловсор,	болбаазыра “боловсрох, боловсон болгох”,
дэбси-,	дэвш ,	депши “амжилттай байх, өөдлөх”,
манд- у ,	манд,	манды “цэцэглэх, ургах”,
сайижира,	сайжир,,	сайзыра “сайжруулах, боловсруулах”,
хөгжи-,	хөгж,	хөгжү “боловсрох” г.м.,
тагалал,	таалал.	:таалал “ханамж, дур баясал, жаргал”
жаргаланг,	жаргалан.	чыргалан “баяр баясал”,
сэргүг-	сэргэг,	сергек “цовоо сэргэлэн”,
мэргэн,	мэргэн,	мерген “мэргэн, ухаалаг, суут”,
көгэрүкүй	хөөрхий	хөөкүй “ядуу, аз жаргалгүй, золгүй”,
эрким,	эрхэм, эргим	“үнэтэй, хонгорхон, хүндэт”,
күчир,	хүчир,	күжүр “ядуу, аз жаргалгүй” г.м.

Энэ бүхнээс дүгнэн үзвэл:

Монгол –тува хэлэнд түгээмэл зүй тогтол байхын зэрэгцээ өвөрмөц зүй тогтол нэлээд байна. Түгээмэл зүй тогтол нь гарлын холбоогоор, өвөрмөц зүй тогтол нь хөгжлийн үр дүнгээр тайлбарлагдах үзэгдэл гэж хэлж болно. Хоёр хэлний түгээмэл зүй тогтол авиалбарын хувьд бүрэлдэхүүн, бүтэх арга, хувьслаар, үгийн бүтцийн хувьд язгуур+дагавар+нөхцөл гэсэн тогтолцоогоор, өгүүлбэрийн бүтцийн хувьд SOV гэсэн гишүүний байрлалын хуулиар, үгийн сангийн хувьд дундын үгийн бүрэлдэхүүнээр нотлогдоно.

Эгшиг авиа нийлэх тохиролд ихэвчлэн хоёр хэлний уугал үг зонхилох байр эзэлж байгаа бол салаалах тохиролд хоёр хэлний үгээс гадна, монгол хэлнээс тува хэлэнд орсон зээлсэн ормол дундын үг нэлээд тохиолдож байна.

Монгол хэлний авиа тува хэлний авиатай сэлгэх хувьсал буй нь мэдэгдэж байгаа боловч хоёр хэлний ижил авианы тохирол хамгийн түгээмэл тохиолддог нь мэдэгдэж байна.

Монгол хэлний үгийн сангаас зээлдсэн байдлыг үзэхэд дараах эх үүсвэр ажиглагдаж байгаа юм. Үүнд:

- Дундад зуун болон түүнээс өмнөх үеийн аман аялгуу 13-15-р зуун,
- Халх аман аялгуу ба орчин үеийн монгол хэл.
- Ойрд аман аялгуу
- Сонгодог бичгийн монгол хэл.
- 1920-оод оны үед монголын нөлөө харьцангуй нэвтэрч байсан.

НОМ ЗҮЙ

- Баасанбат.Д. (2008) *Монгол-манж бичгийн хэлний дундын үг*. Улаанбаатар.,
Базаррагчаа.М. (1987) *Монгол хэлний авиа сэлгэх ёс*. Улаанбаатар.,
Баянсан.Ж. нар. (1995) *Хэшинжлэлийн нэр томъёоны зүйлчилсэн тайлбар толь*. х-198. Улаанбаатар.,
Болд.Л. (1985) *Уйгар урианхай хэлэнд орсон монгол үг*. Өвөр Монгол.,
Гагаа.Ч. (2009) *Тува өвгөний дурдатгал*, х-10.Улаанбаатар.,
Даваасүрэн.Б. (2005) *Алтай овгийн хэлнүүд*. х-1. Улаанбаатар.,
Зоригту.Го. (2000) *Монгол төрлийн хэл ба түрэг төрлийн хэлний үгсийн харьцуулсан судлал*. х-9.Өвөр Монгол
Кунаа.А.Ч. (1970) *Синтаксис простого предложения тувинского языка*. Кызыл.,
Монгуш. Д. А. (1963) *Формы прошедшего времени изъявительного наклонения в тувинском языке*. Кызыл.,
Porre.N. (1965) *Introduction to Altaic Linguistics*. Weisbaden.
Пунцаг.Т. (1985) *Монгол Тува-Орос толь*, Улаанбаатар.,
Монгуш. Д. А. (1980) *Русско-тувинский словарь* Москва.,
Сат. Ш.Ч. (1973) *Формирование и развитие тувинского национального литературного языка*. Кызыл.,
Татаринцев.Б.И. (1976) *Монгольское языковое влияние на тувинскую лексику*. Кызыл.
Татаринцев.Б.И. (1987) *Смысловые связи и отношения слов в тувинском языке*. Москва.,
Төмөртоогоо. Д. (1992) *Монгол хэлний түүхэн хэлзүй-1*, х-1, Улаанбаатар.,
Тенишева. Э.Р. *Тувинско-русский словарь, около 22000 слов*. Советская энциклопедия. Москва.
Тенишева. Э.Р. (1968) *Тувинско-русский словарь*, Москва.,
Ууганбаяр.М. (2008) *Тува хэлэн дэх монгол зээллэг үгсийн авиан зүйн онцлог*// *МУИС.МХСС.ЭШБ №-XXIX* (300) х-138-142. . Улаанбаатар.,
Чадамба.З.Б. (1974) *Тоджинский диалект тувинского языка*. Кызыл.,
Төмөрцэрэн. Ж. (1974) *Монгол хэлний үгийн сан судлал*. Улаанбаатар.,

Товчилсон үгийн жагсаалт

Ба-баяд аялгуу	ОХУ-Оросын Холбооны Улс
БНТУ-Бүгд Найрамдах Тува Улс	То-тод бичиг
Да-дархад аялгуу	Төв-төвд
Дөр-дөрвөд аялгуу	ТРС- тувинско-русский словарь
ЗХУ-Зөвлөлт Холбоот Улс	Тув-тува
МНТ-Монголын нууц товчоо	Тур-турк
Мон бич-монгол бичиг	Хал-халимаг хэл
Монг-монгол	ЭМо-эртний монгол хэл
Ойр: ойрд аялгуу	

SUMMARY

This paper tries to find reason of influencing, origin and correlation of loanwords between Mongolian and Tuvan. It can be concluded that the changes in society, religion, state and culture influenced the origin of the phenomena of borrowing words from each other and consequently, borrowed words have inevitably made their ways to the everyday usage. The words taken as examples are from Mongolian-Tuvan vocabulary of 2,500 loanwords.